



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/598

Хэрлэн сум

Санхүү, эдийн засагчдын өдрийг  
тэмдэглэж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жил бүр уламжлал болгон тэмдэглэн өнгөрүүлдэг Санхүү, эдийн засагчдын тэмдэглэлт өдрийг тохиолдуулан зохион байгуулах арга хэмжээнд зориулан 9,730,000 (есан сая долоон зуун гучин мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлж хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэн арга хэмжээг чанартай зохион байгуулж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023  
оны 11 дугаар сарын 29-ны  
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДАЛЫН ТООЦОО

| № | Зардлын төрөл                    | Тоо | Үнэ     | Нийт      |
|---|----------------------------------|-----|---------|-----------|
| 1 | Баннер                           | 1   | 700 000 | 700 000   |
| 2 | Хоолны зардал                    | 70  | 90 000  | 6 300 000 |
| 3 | Спортын арга хэмжээний<br>шагнал |     |         | 2 400 000 |
| 4 | Хэвлэл                           | 6   | 55 000  | 330 000   |
|   | Нийт                             |     |         | 9 730 000 |